



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 1132

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1.3.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн “Өв Алтай Аргай” холбооноос 2022 оны 04 дүгээр сарын 02-03-ны хооронд зохион байгуулагдах улсын цолтой харваачдад хүндэтгэл үзүүлэх тэмцээний зардалд 7,745,000 (долоон сая долоон зуун дөчин таван мянга) төгрөг, Насанд хүрэгчдийн 2022 оны улсын аварга шалгаруулах шатрын тэмцээнд оролцох Т.Балжинням, Ч.Мягмарсүрэн нарын тэмцээний зардалд 760,000 (долоон зуун жаран мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дээрх 8,505,000 (найман сая таван зуун таван мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0277

D:My Doc. Zahiramj. Zasag darga